



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН 2024-2028 ОНЫ ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ  
ХӨТӨЛБӨРИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨНД  
ЗАМ, ТЭЭВРИЙН САЙДЫН ХАРИУЦАН ХЭРЭГЖҮҮЛЭХ ЗОРИЛТ,  
АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТЭД 2025 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН  
БАЙДЛААР ХИЙСЭН ХЯНАЛТ-ШИНЖИЛГЭЭНИЙ ТОВЧ ТАЙЛАН

2025 оны 06 дугаар сарын 30

Улаанбаатар хот

**Нэг. Хяналт-шинжилгээний зорилго, үндэслэл, арга зүй**

Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр, түүнийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зам, тээврийн сайдын эрхлэх асуудлын хүрээнд тусгагдсан зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ хийж, үнэлэлт, дүгнэлт өгөх, цаашид анхаарч ажиллах талаар санал, зөвлөмж боловсруулах замаар яамны удирдлага, албан тушаалтныг холбогдох мэдээллээр хангах, төлөвлөсөн арга хэмжээг хугацаанд нь хэрэгжүүлэх, зохион байгуулалтын үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх, Засгийн газарт хэрэгжилтийн явцыг тайлагнах зорилгоор энэхүү хяналт-шинжилгээний ажлыг гүйцэтгэлээ.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, Засгийн газрын 2025 оны 218 дугаар тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд туссан зорилго, зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ, хяналт-шинжилгээний үзүүлэлтийн биелэлтийг гаргаж, Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ хийх журам”-ын 6.1, 6.3, 6.4-т заасан арга зүйг баримтлан ажилласан болно.

**Хоёр. Төлөвлөсөн арга хэмжээний хэрэгжилтийн байдал**

Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөнд 2025 онд зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх 80 арга хэмжээ тусгагдсанаас 26 арга хэмжээг ХЗДХЯ/1/, ШСАА/5/, БОУАӨЯ/3/, ЭЗХЯ/1/, ЦХИХХЯ /4/, ССАЖЯ /4/, НЗДТГ /8/-тай хамтран, 54 арга хэмжээг Зам, тээврийн сайд дангаараа хариуцан хэрэгжүүлэхээр туссан байна.

Засгийн газрын 2025 оны 43 дугаар тогтоолоор баталсан “Хяналт-шинжилгээ, хийх журам”-ын дагуу үнэлэхэд Зам, тээврийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний тайлангаас бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх 80 арга хэмжээний хэрэгжилтийн үнэлгээ 63.94 хувь, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж өссөн дүнгээр 38.79 хувьтай байна.

Зам, тээврийн сайдын дангаараа хэрэгжүүлэх 54 арга хэмжээний хэрэгжилт 51.83 хувьтай, төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж өссөн дүнгээр 20.81 хувьтай байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн үр дүнгийн нийт үнэлгээ 100 хувь, хөтөлбөрийн үр дүн 82.14 хувийн хэрэгжилттэй байна.

**Гурав. Дүгнэлт**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөөний Зам, тээврийн сайдын эрхлэх асуудалд хамаарах 80 арга хэмжээний хэрэгжилтийн үр дүн дараах байдалтай байна.

3.1. Зам, тээврийн сайдын 2025 онд хэрэгжүүлэх 80 арга хэмжээний хэрэгжилт эхний хагас жилийн байдлаар төсөл арга хэмжээний хэрэгжилтийн дундаж үнэлгээ 63.57 хувьтай байгаа бөгөөд үндсэн хэрэгжүүлэгчийн 54 арга хэмжээний үнэлгээ 51.83 хувьтай буюу хэрэгжилттэй зорилтот түвшний 30-59 хувь буюу "үр дүн хангалтгүй" үнэлэгдлээ.

3.2. Төсвийн ерөнхийлөн захирагчийн шалгуур үзүүлэлтийн үр дүн 100 хувь, хөтөлбөрийн шалгуур үзүүлэлтийн үр дүн 84.14 хувийн хэрэгжилттэй, зорилтот түвшний 85 хувиас дээш буюу "Үр дүн гарсан" байна.

Зам, тээврийн салбарын төсөл арга хэмжээний хэрэгжилтийн тайланд хийсэн хяналт-шинжилгээний дүнгээс харахад санхүүжилтийг шийдвэрлүүлэхээр холбогдох байгууллагад санал хүргүүлсэн, тендер зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй, ТЭЗҮ, зураг төслийн шатанд, санхүүгийн урьдчилсан тооцооллыг хийж байгаа, Төр хувийн хэвшлийн түншлэлийн тухай хуулийн хүрээнд төслийн шинжилгээ хийн ажиллаж байгаа төсөл, арга хэмжээг "шалгуур үзүүлэлт"-д хүргэх, холбогдох бусад байгууллагатай хамтран хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг "эзэнжүүлэх" төлөвлөгөөг батлуулан, хэрэгжилтийг хангуулж ажиллах нь зүйтэй гэж дүгнэж байна.

#### **Дөрөв. Цаашид авах арга хэмжээний санал, зөвлөмж**

Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан Зам, тээврийн салбарт хэрэгжүүлэх зорилт, арга хэмжээний хэрэгжилтэд хагас жилийн байдлаар хяналт-шинжилгээ хийж, дараах зөвлөмжийг хүргүүлж байна. Үүнд:

4.1.Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр (төлөвлөгөө)-нд туссан "Зам, тээврийн салбарын эрхлэх асуудлын хүрээний болон хамтран хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-г Сайдын тушаалаар 10 дугаар сард багтаан батлуулан, эзэнжүүлж, үүрэг хариуцлагыг нэмэгдүүлэхийг Бодлого, төлөвлөлтийн газар болон Бодлого, зохицуулалтын газруудад;

4.2. Хяналт-шинжилгээ, үнэлгээний журам, үнэлэх аргачлал өөрчлөгдсөнтэй холбоотой Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газрууд БТГ, ХШҮДАГ-тай хамтран батлагдсан бодлогын баримт бичгүүдийн шалгуур үзүүлэлт, суурь түвшин, зорилтот түвшин, хэрэгжилтийн байдлыг хэлэлцэн, Удирдлагад танилцуулах;

4.3. Засгийн газрын 2024-2028 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөнд зам, тээврийн салбарын чиглэлээр тусгагдсан төсөл арга хэмжээг бүрэн хэрэгжүүлж ажиллан, үр дүнгийн үзүүлэлт, санхүүжилт, түүний зарцуулалтыг үнэн, зөв тайлагнаж, тогтоосон хугацаанд Бодлого, төлөвлөлтийн газарт хүргүүлэн ажиллахыг Бодлогын хэрэгжилтийг зохицуулах газруудад тус тус зөвлөж байна.

---o0o---